

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-Н ДАРГА:

Ц.УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“СУННО ИНТЕРНЭШНЛ” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Д.САНСАРМАА

**“СУННО ИНТЕРНЭШНЛ” ХХК-НИЙ НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ
ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ, ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОР ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2717964/**

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-Н МЭРГЭЖИЛТЭН:

П.ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨНИЙ

“ЭНВИШНГРИЙН” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Б. ТҮВШИНЖАРГАЛ

Улаанбаатар хот

2023 он

Гарчиг

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	3
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	8
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
9.1. Зорилго	16
9.2. Хууль, эрхзүйн орчин	16
9.2.1. Монгол улсын хууль	16
9.2.2. Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаас	19
9.2.3. Стандартууд	19
9.2.4. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба менежментийн хяналт	19
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	28
АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	31
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	32
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	33
ХАВСРАЛТУУД	33

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

“Сунно Интернэшнл” ХХК нь 2006 онд анх байгуулагдсан бөгөөд гадаад худалдаа, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн болно.

Бидний хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын бааз” төсөл нь байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэсэн монголын аялал жуулчлалын салбарт өөрсдийн хувь нэмрээ оруулсан бодиттой ажил болно гэж үзэж байна.

Төслийн үндэслэл

“Сунно Интернэшнл” ХХК нь “Аялал жуулчлалын бааз” төслийг боловсруулсан болно.

Төслийн үндэслэл нь энэхүү төслийг аялал жуулчлалын салбарт хувь нэмэр оруулсан хэлбэрээр хэрэгжүүлэх, нөгөө талаас Улаанбаатар хотын иргэдийн болон гадаад орнуудаас Монгол оронд ирэх жуулчдыг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор ая тухтай аялж, амруулах нөхцлийг бүрдүүлэх зорилгыг албан ёсны үндэслэлээ болгон авч үзсэн юм.

Аялал жуулчлал нь сүүлийн жилүүдэд дэлхий дахинд автомашин, нефтийн үйлдвэрлэлийн дараагаар тэргүүлэх салбаруудын нэг болон хөгжиж байна. Манай орны тэгш тал, өвс ургамалаар хучигдсан өндөрлөг газруудыг дотроо агуулсан өргөн уудам тал хээр нь газар нутгийн ихэнхийг эзэлдэг ба манай байгалийн төрх байдал, нүүдлийн соёл иргэншил, түүх соёл, архелогийн ховор дурсгал нь аялал жуулчлалын нөөц болдог учир түүнийг хөгжүүлэх үндэс суурь болж байна. Манай улсад 1990-д оноос хойш аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулах болсон тур оператор компаний тоо эрс ихсэж, манай улсад амрах аялалыг ихээр явуулах болсон нь тэдгээрийн хоорондын өрсөлдөөн, бие биенээсээ давамгайлахыг оролдох оролдлого гарч ирж байгаа ч нэг талаас мэргэжлийн боловсон хүчин дутмаг учраас зөв төлөвлөж, зохион байгуулж чадахгүй байгаагаас тогтвортойгоор чанартай бүтээгдэхүүн, цогц амралт, аялалыг хийж чадахгүй байна.

Иймд чанарын өндөр түвшний амралтын газрыг гаргаж, шинэ төрлийн аялалыг санаачлах асуудал чухал байна.

Төслийн зорилго

- ❖ УБ хотын болон гадаадын жуулчдын аялж амрах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах
- ❖ Үзэсгэлэнт байгалийг түшиглэн тохь тухтай, соёлтой үйлчилгээ бүхий өндөр зэрэглэлийн амралтын газар байгуулах
- ❖ Байгалийн сайханд түшиглэсэн ногоон хөгжил хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн байгалийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр иргэдийн орлогыг тогтвортойгоор дээшлүүлэн ногоон худалдан авалтыг хийхэд оршино.
- ❖ Ажлын байр бий болгох

Төслийн хүчин чадал

“Сунно-Интернэшнл” ХХК-ний аялал жуулчлалын бааз нь хоногт 80-100 хүн хүлээн авах хүчин чадалтайгаар 2007 онд байгуулагдсан. Одоогоор улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна.

Төсөл хэрэгжиж буй талбайд ресторан, амрагчдын амрах гэр сууц, ариун цэврийн өрөө, душ, саравч, агуулахын байр зэрэг байгууламж байна. Амрагчид чөлөөт цагаа өнгөрүүлэх сагсны болон гар бөмбөгийн талбайтай.

“Аялал жуулчлалын бааз” төслийн барилга байгууламж, тоног төхөөрөмж

- Иж бүрэн тохижилт бүхий амрагчдын гэр сууц 28 ш /4 ортой 18 гэр, 3 ортой 10 гэр/
- Ресторан /Нэг ээлжиндээ 100 хүн хүлээн авах хүчин чадалтай/
- Ариун цэврийн байгууламж /Эрэгтэй-3, Эмэгтэй-3 ариун цэврийн өрөө, угаалтуур-6, шүршүүр эрэгтэй-4, эмэгтэй-3, угаалгын өрөө/
- Бохирын цооног /Хоолны газрын 6 тн, ариун цэврийн байгууламжийн 18 тн-ийн багтаамжтай/
- Агуулах
- Задгай сүүдрэвч
- Автомашины зогсоол
- Одон орны дуран, сансар огторгуйн тайлбар хийх прожектор, дэлгэц, хоолой
- Гүний насос бүхий худаг.



Зураг 1. Амралтын газрын зохион байгуулалт

Гүйцэтгэгч байгууллагын товч мэдээлэл:

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл	
1	Төслийн нэр	Аялал жуулчлалын бааз	
2	Гүйцэтгэгч аж ахуйн нэр	“Сунно Интернэшнл” ХХК	
3	Улсын бүртгэлийн дугаар	9011078038 РД: 2717964	
4	Талбайн байршил	Улаанбаатар хот Налайх дүүрэг 6-р хороо Бумбагар хад нэртэй газарт	
5	Байгаль орчин хариуцах ажилтан	Албан тушаал	Захирал
		Нэр	Д.Сансармаа
		Утас	80003635

Ажлын гүйцэтгэл ба төлөвлөгөө

Энэхүү БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОМТ) нь Улаанбаатар хотын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжиж буй Аялал жуулчлалын бааз төслийн ажлыг гүйцэтгэх үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

МУ-н засгийн шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аялал жуулчлалын салбарыг сэргээх бодлого болон 2023-2024 оныг МУ-н ЗГ-с “Монголд зочлох жил” болгон зарласан зэрэг төр засгийн бодлого, эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах болно. Ялангуяа БНСУ, Япон, Хятад зэрэг гадаад улсаас ирэх жуулчдыг баазынхаа хүчин чадлын хүрээнд хүлээн авч ажиллах бөгөөд энэ талд анхаарч ажиллах болно.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Зураг	Агуулга	Утга
	Гүйцэтгэгч:	“Сунно Интернэшнл” ХХК
	Байршил:	Улаанбаатар хот Налайх дүүрэг 6-р хороо Бумбагар хад нэртэй газар
	БОННУ огноо:	2019 онд “Өндөрхаан трейд” ХХК
	Ажил эхэлсэн огноо:	2019 онд
	Ажил дууссан огноо:	2023 онд
	Зорилго:	Аялал жуулчлалын бааз байгуулах.
	Ажлын хэмжээ:	Тус амралтын газар нь нэг дор 100 хүн хүлээн авах чадалтай

№	Өргөрөг	Уртраг
1	47°52'47.37"N	107°23'26.11"E
2	47°52'48.21"N	107°23'27.13"E
3	47°52'48.95"N	107°23'26.08"E
4	47°52'50.82"N	107°23'29.88"E
5	47°52'50.87"N	107°23'30.41"E
6	47°52'50.78"N	107°23'31.70"E
7	47°52'49.85"N	107°23'32.17"E
8	47°52'49.55"N	107°23'31.28"E
9	47°52'49.90"N	107°23'30.96"E
10	47°52'49.31"N	107°23'29.29"E
11	47°52'48.40"N	107°23'31.10"E
12	47°52'47.98"N	107°23'30.90"E
13	47°52'47.35"N	107°23'31.79"E
14	47°52'46.33"N	107°23'30.73"E

Уг төсөл нь Улаанбаатар хот Налайх дүүрэг 6-р хороо Бумбагар хад нэртэй газарт байрлана.



Зураг.2. Төслийн талбай

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн гол сөрөг нөлөөлөл

Аялал жуулчлалын бааз төслийн нэмэлт ажилтай холбоотой гол сөрөг нөлөөллийн үнэлгээг БОАЖЯ-ны сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу болон нөлөөллийн оноот үнэлгээний аргыг хоёр янзаар тооцсон. Үүнд: Хөрс хуулалт, газар ухах, буцаан булах, зам тавих, шугам хоолой тавих үйл ажиллагаа тус бүрээс үзүүлэх нөлөөлөл болон байгалийн бүрэлдэхүүн бүрт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг тус тусад нь авч үзэн судалсан.

Нэмэлт бүтээн байгуулалт хийх, кабель татах үед газар шорооны ажил, хөрс хуулалт, газар ухах, барилгын материал, техник, тоног төхөөрөмж зэргийг ажлын талбай дээр авчрах, нүүлгэн шилжүүлэлтийн болон барилгын үлдэгдэл бетоны хольц, хог хаягдлыг тээвэрлэх, ачих буулгах, машин техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хөдөлгөх үед ажлын талбайн хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг доройтох, ил задгай барилгын хог хаягдлаар бохирдох, тоос, дуу чимээний бохирдол ихсэх зэрэг түр зуурын нөлөөллүүд үүснэ.

Аялал жуулчлалын баазын нэмэлт ажлын төлөвлөж буй талбайд аж ахуйн хашааг байгуулан амрагчдын түр амрах саравч, усан оргилуур, хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам, мод тарих талбай, авто зогсоол гэх зэрэг барилга баригдах юм.

Байгаль орчны бүрэлдэхүүнд тус бүрт үзүүлж болзошгүй нөлөөлөл

№	Үзүүлэлт	Нөлөөллийн түвшин	Тайлбар
1	Газрын хэвлий рельеф	Их	Ажлын үед шинээр газар ухах, суваг, шуудууны ажил хийгдэх тул энэ төрлийн нөлөөлөл их гэж үзлээ.
2	Цаг уур, уур амьсгал	Дунд	Цаг агаарын нөхцөл байдлаас ил барилга угсралтын ажиллагаа шууд хамааралтай байдаг бөгөөд цаг уурын таагүй байдлаас барилгын ажил зогсох, удаашрах зэргээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хугацаа уртасна. Хүчтэй салхи, шороон шуургаар ил задгай барилгын болон ажилчдын хог хаягдал хийсч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлж болзошгүй.
3	Агаарын чанар	Бага	Техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ. Төслийн талбайд ажиллах техникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна.
4	Усан орчин	Бага	Төслийн талбайн нөлөөллийн бүсэд гадаргын уст цэг байгаа тул нөлөөлөл үзүүлнэ, гүний усны түвшинд барилгын ажил явагдахгүй учраас нөлөөлөхгүй.
5	Хөрс, газрын гадарга	Их	Ажлын үед хөрс хуулалт, газар ухалтын ажил хийгдэх тул энд үзүүлэх нөлөөллийг их зэрэг гэж үзсэн.
6	Ургамал	Их	Нэмэлт бүтээн байгуулалтын ажил явагдах талбай нь эрүүл газар учир барилга баригдах талбай, хүний үйл ажиллагаа техникийн үед ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх юм. Энэ нь баригдаж дуусах үе хүртэлх нөлөөллийн эрчим их байна.
7	Амьтан	Нөлөөлөлгүй	Нэмэлт ажлын суурин газар учир хүн болон техникийн хөдөлгөөн, дуу чимээ ихтэй тул мэрэгч амьтад болон бор шувууны багийн жижиг шувууд болон синнантроп зүйлүүдээс бусад амьтад ерөнхийдөө дайжсан учир төслөөс амьтанд үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй.
8	Дуу чимээ, доргилт, чичиргээ	Бага	Нэмэлт ажлын дуу чимээ, чичиргээ нь ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
9	Үнэр	Бага	Ажилчдын нүхэн жорлонгийн үнэр тархах нь бага юм.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Хэдийгээр төслийн үйл ажиллагаа нь байгаль үзүүлэх хүчтэй, том хэмжээний талбайг хамарсан нөлөөлөл үүсэхгүй боловч бичил экосистемд бага хэмжээний нөлөөлөл бүрэн арилгаж ажиллах нь зүйтэй юм.

Ажилчдын болгоомжгүй санамсаргүй үйл ажиллагаанаас үүдэлтэй томоохон хэмжээний аюул, осол гарч болзошгүй бөгөөд эрсдэлийн үнэлгээний хэсэгт заасны дагуу технологийн заавар, дүрэм, санамж зэргийг байнга даган мөрдөн ажиллах зайлшгүй шаардлагатай болно.

МУ-н УИХ-с 2014 онд батлагдсан 43-р тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлогын” 3.3.4.-д байгаль орчинд халтай үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний импорт, хэрэглээг багасгахад чиглэсэн ногоон татварын системийг бий болгох гэж заасны дагуу ногоон үйлдвэрлэл, худалдааг дэмжин ажиллах нь гол юм.

Тухайн жилийн БОМТ-ний гол зорилтуудыг дараахь байдлаар тодорхойлж байна.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх
- Үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулах
- Хог хаягдлыг дахин боловсруулах хэлбэрээр нь ангилан ялгаж, боловсруулах үйлдвэрт нийлүүлэх
- Ногоон байгууламжыг нэмэгдүүлж, тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллах

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Төсөв мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
A	Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ					
A-1	<ul style="list-style-type: none"> - Ажлын үед шинээр газар ухах, суваг, шуудууны ажил хийгдэх - Амрагч, жуулчдад болон амралтын газрын болзошгүй үйл ажиллагаанаас гэнэтийн асгаралт үүсэх - Маршрутын бус замаар амрагчид байнга зорчсноос үүсэх хөрсний элэгдэл 	Амрагчид болон баазын үйл ажиллагааны явцад хөрсөнд бохир ус, бусад төрлийн асгаралт үүсгэхгүй анхаарч ажиллах	Төсөл хэрэгжүүлэх явцад	2023 оны 4-р сараас эхлэн 10-р сар дуустал	ХАБЭА-н зардал	<p>MNS 5850 :2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ</p> <p>“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль”, 2012 он</p>
A-2		Техникийн тос, шатахууны асгаралт гарсан тохиолдолд байгаль орчин, аюулгүй ажиллагааны ажилтнууд асгаралтыг таслан зогсоох, асгарсан тосыг шингээж авах, цаашилбал бохирдсон хөрсийг саармагжуулах буюу хоргүйжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх асгаралтын хариу үйлдэл хийх төлөвлөгөө боловсруулах		2023 оны 4-р сараас эхлэн 10-р сар дуустал	ХАБЭА-н зардал	
A-3		Амрагч, жуулчдад зориулсан баазын маршрут, аялалын зураглал, зөвлөмжийг танилцуулж ажиллах		2023 оны 4-р сараас эхлэн 10-р сар дуустал	ХАБЭА-н зардал	
A-4		Хөрс хамгийн ихээр бохирдож болзошгүй газруудад тогтмол хүнд металлын шинжилгээ хийлгэж стандартын хэмжээнд байлгах		Жилд 2 удаа	ОХШХ-т тусгасан	
A-5		Ухсан нүх, цооногийг тухай бүрт нь булж тэгшилж байх		БО-ны ажилтан Тохиолдол бүрт	Үйл ажиллагаа ны зардал	

Б	Агаарын бохирдол, тоосыг бууруулах арга хэмжээ					
Б-1		Тоос үүсэх нөхцлийг хамгийн бага байлгахыг анхаарч, шаардлагатай үед усаар шүршиж тоос бууруулах системийг ашиглах.		Байнгын хийгдэх ажлууд ТУН ба БОХХ хяналт тавьж ажиллана. Жилд 2 удаа мониторинг хийнэ.	-	
Б-2	Нэмэлт ажил хийх, техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ.	Баазын үйл ажиллагаанд ашиглаж буй техникийг шаардлага хангах бүрэн техник, тоног төхөөрөмж сонгох, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгана.	Төсөл хэрэгжүүлэх явцад	Тогтмол	-	MNS 4585:2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага “Агаарын тухай хууль”, 2012 он “Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль” 2010 он
Б-3	Нэмэлт ажлын талбайд ажиллах техникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна.	Амрагчдын машин техникийг удаан асалттай байлгахгүй, шороон замаар явах үед хурдны хязгаар 20-30 байх ёстой зөвлөмжийг өгч ажиллах		Тогтмол	ХАБЭА-н зардал	
Б-4		Агаарын бохирдолд хяналт шинжилгээ хийх		ОХШХ-т тусгасан БО-ны мэргэжилтэн	ОХШХ-т тусгасан	
В	Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ					
В-1	Төслийн талбайн байгаа гүний уст цэгт болзошгүй нөлөөллөөс бохирдол нэвчих орох	Зуны улиралд эрчимтэй орсон аадар борооны үед үер болох нөхцөлтэй тул амралтын газрын бохир усны цооног усанд автаж болзошгүй тул үерийн үед авч хэрэгжүүлэх яаралтай арга хэмжээг төлөвлөх, Байгалийн гэнэтийн эрсдэлийг урьдчилан тооцох, учирсан тохиолдолд яаралтай авах арга хэмжээний хөтөлбөр боловсруулах	Төсөл хэрэгжих явцад	ХАБЭА-н инженер Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардал	“Усны тухай хууль” 2012 он “Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль”, 2012 он ISO 5667-1 Water quality, Sampling (Guidance on the design of sampling programmes and sampling techniques) MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3342 - 1982 2 х Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага ISO 5667-3 20012/11/15 Water quality Sampling (Part3 Preservation and handling of water samples) 13 ISO 14403-2 2012/7/15 Water quality
В-2		Аялал жуулчлалын баазын гүний худагт усан орчны хяналт шинжилгээ хийх		БО-ны мэргэжилтэн ОХШХ-т тусгасан	ОХШХ-т тусгасан	
В-3		Байгалийн хур тунадасны усыг хуримтлуулан ногоон байгууламжын усалгаа болон техникийн цэвэрлэгээ зэрэгт ашиглах		ХАБЭА-н инженер Үйл ажиллагааны турш		

						Determination of total cyanide and free cyanide using flow analysis (FIA and CFA), Part2 Method using continuous flow analysis (CFA) MNS BS 8525-1:2015. Саарал усны систем. Ерөнхий шаардлага
Г	Дуу чимээний нөлөөллийг бууруулах арга хэмжээ					
Г-1	Аялал жуулчлалын бүсэд хэрэгжиж буй учир амрагчид болон бусад амралтын газарт амарч буй иргэдэд нөлөөлөл үзүүлнэ.	Шөнө оройн цагаар шоу цэнгээн болон урлагын үйл ажиллагаа явуулахгүй, дуут дохио сигналыг байнга өгөхгүй байх.	Барилгын ажлын явцад	Тогтмол	-	Ажлын цаг баримтлаж ажиллах
Г-2		Орчны дуу чимээний бохирдлыг хянах		ОХШХ-т тусгасан	ОХШХ-т тусгасан	Зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байх

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн төслийн талбайн нутаг дэвсгэртээ иргэдийн хуулиар баталгаажсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, байгаль орчин, ногоон хөгжлийн суурь үзэл санааг хэрэгжүүлэн хүн аюулгүй, эрүүл амьдрах нөхцлийг бүрдүүлж, үйл ажиллагаа дууссаны дараа тухайн орчинд экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, хүн, мал амьтан болон биологийн төрөл зүйл амьдрахад аюулгүй амьдрах орчинг бий болгоход нөхөн сэргээлтийн гол зорилго оршино. Байгалийн нөөц баялгийг тогтвортой ашиглах, жам ёсоор нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэхэд оршино. Үүнд:

- ✓ Хойч үедээ экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан
- ✓ Бохирдуулагч төлөх ёстой зарчмыг баримтлах
- ✓ Биологийн төрөл зүйлийг хамгаалах
- ✓ Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан хамаарал, холбоо, тэнцвэрт байдлыг хадгалах

Мөн МУ-н ерөнхийлөгчийн зарлиг гарган хэрэгжүүлж буй Тэрбум мод тарих үндэсний хөтөлбөрт дэмжлэг үзүүлж ажиллана.

Нөхөн сэргээлтийн арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Хэрэгжүүлэгч	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нэмэлт ажлын төлөвлөсөн хил хязгаарт үйл ажиллагаа явуулах	Нэмэлт ажлын турш	“Сунно Интернэшнл” ХХК	Төслийн талбайд	ш	Мод – 30 ш Сөөг – 20 ш	Бордоо – 4000 x 284 кг = 1,135,800	2 935 800	MNS 5914:2008
2	Аялал жуулчлалын баазын талбай болон амрагчдын гэр, байшин, талбайн тохижуулалтын ажлын барилгын дараах үлдсэн талбайд эзэмшил газрын 30 хүртэл хувьд /ХБТХууль 12.6.3/ ногоон байгууламж болон гадна тохижилтын ажил	Баазын талбайд мод тарих					Олон наст ургамлын үр – 25,000 x 8 кг = 200,000		MNS 5915:2008
			Модны үнэ – 40,000 x 30 ш = 1 200'000	MNS 5916:2008					
			Сөөгний үнэ – 20,000 x 20 ш = 400'000	MNS 5917:2008					
								MNS 5918:2008	

3	Мод тарих	Тухай бүрт нь ургамлын үр суулгах				Зүлэгжүүлэх талбай – 1000 м ² Бордоо – 284 кг Олон наст ургамлын үр – 8 кг			
---	-----------	-----------------------------------	--	--	--	---	--	--	--

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч аливаа аж ахуйн нэгж, байгууллага МУ-ын Соёлын өвийн тухай хуульд заасны дагуу түүх, соёлын өвийг авран хамгаалах үүрэгтэй байдаг.

“Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйлд “газрын хэвлийг ашиглах явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” Хэрэв энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд 200.000-250.000 төгрөгөөр торгож, үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ хийх, хувилан олшруулах, хуулбар хийх, хадгалалтыг зогсоох, хууль бусаар олсон орлогыг хураах арга хэмжээ авахаар заажээ.

Соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Түүх, соёлын дурсгалт зүйл	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл барилгын ажлаа зогсоож энэ тухай, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Төслийн хүрээнд	-	Тухайн үед нь шийдэх	Нэмэлт бүтээн байгуулалтын ажлын үед, дэд бүтцийн бүтээн байгуулалтын үед буюу Тухай бүрт нь	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арилгах, арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг/мян.төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах	Нийт төсөл хэрэгжих талбайн барилга байгууламжид	-	450 000	2023 онд	Гамшгаас хамгаалах тухай
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	100.0		2023 онд	MNS OHSAS-18001:2012
	Үерийн усны хамгаалалтын далан, жалга сайрыг цэвэрлэж байх	Төслийн талбай орчим	-		Төслийн үйл ажиллагааны явцад	БД 12-105-07 БД 12-101-05
	Өөрийн байгууламжид үер усны аюул, гал түймрээс урьдчилан сэргийлэх бүдүүвч схем боловсруулан батлах	Төслийн хүрээнд	-		2022 онд	БНБД 12.03.04 БНБД 12.04.06 БД 12-106-14
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд 1 удаа зохион байгуулах, дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай хариуцан холбоотой ажиллах	Бүх ажилчдад	200.0		2022 онд	БНБД 21-01-02 БНБД 12-01-03 MNS 5414:2004 MNS 5415:2004
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Төслийг бүхэлд нь	150.0		Жил бүр	MNS 00112-4-00:85 MNSISO13688:2000

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь “Сунно Интернэшнл” ХХК-ийн “Аялал жуулчлалын бааз” төслийн барилгын ажлын явцад гарч болох хог хаягдлын эх үүсвэрийг Монгол улс болон олон улсын хууль тогтоомж, стандарт шаардлагын дагуу хянах, бууруулахад чиглэгдэх юм.

Аливаа үйлдвэрлэл, төслийн үйл ажиллагаанаас үүдэн хог хаягдал үүсгэх нь зайлшгүй бөгөөд холбогдох хууль, журмын дагуу хог хаягдлын менежментийг системийн арга хандлагыг тодорхойлсон болно.

Төлөвлөгөөнд төслийн холбогдох стандартуудыг тогтоох, нөлөөлөл бууруулах арга хэмжээний хяналт шинжилгээ ба аудитын хөтөлбөр зэрэг төслийн хог хаягдлын менежментийн удирдлагуудыг тогтоож өгсөн.

9.1. ЗОРИЛГО

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилгууд нь:

- ✓ Хог хаягдлын менежментийн талаархи дотоодын болон олон улсын хууль, журам, стандартуудыг тодорхойлох;
- ✓ Барилгын ажлын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын нөлөөллийн болзошгүй эх үүсвэрүүдийг тодорхойлох;
- ✓ Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны журмуудыг тодорхойлох;
- ✓ Үүрэг, хариуцлагуудыг тодорхойлох;
- ✓ Хяналт шинжилгээ/аудит болон тайлагнах журмуудыг тодорхойлох;
- ✓ Ажилчдад зориулсан сургалт зэрэг багтана.

9.2. ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН

Хог хаягдлыг цуглуулах, ялгах, хадгалах, боловсруулах, зайлуулахтай холбоотой Монгол улсын болон олон улсын дүрэм журам, стандартуудыг заасан болно.

9.2.1. Монгол улсын хууль

“Хог хаягдлын тухай хууль” 2017 он

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн зүйл, заалтууд

10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг эрх, үүрэг

10.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх эдэлнэ:

10.1.1. хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;

10.1.2. хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.

- 10.2.Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:
10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;
10.2.2.энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх;
10.2.3.аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;
10.2.4.хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
10.2.5.үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
10.2.6.нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох;
10.2.7.хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;
10.2.8.хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;
10.2.9.эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;
10.2.10.энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;
10.2.11.барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;
10.2.12.хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;
10.2.13.хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
10.2.14.хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
10.2.15.хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
10.2.16.аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;
10.2.17.үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;
10.2.18.аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.
10.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно:
10.3.1.хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;
10.3.2.нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;
10.3.3.хог хаягдлыг ил задгай шатаах;
10.3.4.гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;
10.3.5.хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;
10.3.6.аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;
10.3.7.нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.
- 14 дүгээр зүйл. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх**
14.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан байна.
14.2.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.
14.3.Энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.
14.4.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө.
14.5.Энэ хуулийн 14.4-т заасан хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгнө.
14.6.Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
14.7.Энгийн хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.
14.8.Энэ хуулийн 14.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.
- 40 дүгээр зүйл. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах**
40.1.Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэнэ.
40.2.Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ дахивар нөөц сонгож, хаягдалгүй болон хамгийн бага хог хаягдал гаргах технологи ашиглана.

40.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дахин боловсруулсан, сэргээн ашигласан бүтээгдэхүүн худалдан авах замаар ногоон худалдан авалтыг дэмжинэ.

40.4.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгоно.

40.5.Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй.

40.6.Үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах, экспортлох амьдралын мөчлөгийг харуулсан схемтэй байх ба түүнийг олон нийгэд нээлттэй байлгана.

40.7.Хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн бүтээгдэхүүн болон дахин боловсруулагдах хог хаягдал үүсгэх бүтээгдэхүүн нь энэ хуулийн 8.1.13-т заасан таних тэмдэгтэй байна.

40.8.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах байгууламж болон хог хаягдлын төвлөрсөн цэг, үйлдвэр технологийн паркийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

41 дүгээр зүйл.Хог хаягдлын үйлчилгээний хураамж

41.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө.

41.8.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ.

41.12.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих, бүх нийтийн их цэвэрлэгээ, сургалт, сурталчилгаа зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт тусгаж зарцуулна

43 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

43.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ:

43.1.1.энэ хуулийн 7.1.2-т заасан журмыг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

43.1.2.энэ хуулийн 8.2.1, 8.3.2, 8.5.1, 8.6.2, 9.1.3-т заасан журмыг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.3.энэ хуулийн 10.2.1, 10.2.4, 10.2.5, 10.2.7, 10.2.9, 10.2.10, 10.2.11-д заасныг зөрчсөн бол хүнийг гучин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.4.энэ хуулийн 10.3.1, 10.3.2-т заасныг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.5.энэ хуулийн 10.3.3, 10.3.4-т заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.6.энэ хуулийн 10.3.5-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.7.энэ хуулийн 10.3.6-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.8.энэ хуулийн 10.3.7-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.9.энэ хуулийн 14.4, 14.5, 14.6, 14.8-д заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.10.энэ хуулийн 14.3-т заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.11.энэ хуулийн 16.8-д заасныг зөрчсөн хүнийг таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.12.энэ хуулийн 18.1-д заасныг зөрчсөн хүнийг таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

43.1.13.энэ хуулийн 20.1, 20.2-т заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.14.энэ хуулийн 20.4-т заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.15.энэ хуулийн 24.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгох;

43.1.16.энэ хуулийн 25.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.17.энэ хуулийн 26.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.18.энэ хуулийн 28.1-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.19.нийтийн эдэлбэр газар болон ногоон бүсэд хог хаягдал хаясан иргэн, аж ахуйн нэгжийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг хурааж, зөрчил гаргасан хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван сая төгрөгөөр торгох;

43.1.20.энэ хуулийн 40.5-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг таван сая төгрөгөөр торгох;

43.1.21.энэ хуулийн 40.6-д заасныг зөрчсөн хүнийг нэг зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;
43.1.22.энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх.

9.2.2. Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаас

№	Нэр	Батлагдсан огноо, актын дугаар
Сайдын тушаал		
1	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага	БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт
2	Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал	БОАЖС-ын 2017 оны А/368 дугаар тушаалын хавсралт
3	Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам	БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн а/428 дугаар тушаалын хавсралт
4	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалын хавсралт

9.2.3. Стандартууд

Монголын улсын стандартууд

- ✓ “Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага” MNS 5344 - 2011
- ✓ “Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөв” MNS 6342- 2012 5х

Олон улсын стандартууд

- ✓ ЕХ-ны хог хаягдлыг ландфил хийх тухай захирамж 99/31/ЕС (1999 он);
- ✓ ЕХ-ны хог хаягдлыг шатаах устгах тухай захирамж 2000/76/ЕС (2000 оны 12 сарын 4- ны өдөр);
- ✓ ДЭМБ-ын Эрүүл мэндийн салбарын аюулгүй хог хаягдлын менежмент: Бодлогын баримт бичиг, бүртгэлийн хуудас № 281, (эрүүл мэндийн салбарын хог хаягдлын менежмент);
- ✓ Аюултай хог хаягдлын хил дамжсан хөдөлгөөний хяналтын тухай конвенци, хог хаягдлыг устгах конвенци (Базелын конвенци, Монгол улс 1997 онд нэгдсэн);
- ✓ US EPA стандартууд CFR 258 (Хотын хатуу хог хаягдлыг ландфилдэх шалгуур) төсөлд хэрэгжүүлэхээр баталсан;

9.2.4. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба менежментийн хяналт

Хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулахын тулд нөлөөлөл бууруулах арга хэмжээ болон менежментийн хяналтыг барилгын ажлын үед хэрэгжүүлнэ. Гэрээт гүйцэтгэгчид нь доорх хүснэгтэнд тодорхойлсон арга хэмжээнүүдийг өөрсдийн ажлын дүрэм журманд тусган дагаж мөрдөнө. Мөн туслан гүйцэтгэгчийн төлөвлөгөөнүүдэд доор дурьдсан шаардлагуудыг дагаж мөрдөхөөр оруулж өгсөн байх ёстой.

“Аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг,

“энгийн хог хаягдал” гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг, “ахуйн хог хаягдал” гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг тус тус хэлнэ.

Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр болон үйл ажиллагааны явцад дахин ашиглах, хүнсний хаягдал, үнс болон бусад гэсэн төрлөөр заавал ангилна.

Энгийн хог хаягдал

Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалж, орон нутагт хамгийн ойр хоёрдогч түүхий эд цуглуулах цэгт хүргэнэ.

Дахин ашиглах боломжтой хог хаягдалд дараах хог хаягдал хамаарна:

- ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/
- ✓ Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/
- ✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл;
- ✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/;
- ✓ Лааз;
- ✓ Мод, модон эдлэлийн хаягдал;
- ✓ Хувцас, даавуун эдлэл;
- ✓ Савхи, резин;
- ✓ Өвс, мод.

Дахин ашиглах боломжгүй хатуу хог хаягдалд дараах энгийн хог хаягдлууд хамаарч байна.

а/ Хүнсний хог хаягдал. Үүнд:

- ✓ Хоолны үлдэгдэл;
- ✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл;
- ✓ Хэрэглэсэн хүнсний тос.
 - б/. Халаалтын болон уурын зуухны үнс;
 - в/. Бусад хог хаягдалд дараах хог хаягдал орно:
- ✓ Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- ✓ Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- ✓ Боловсруулсан дахин ашиглах боломжгүй бохир хөрс, шороо, чулуу, элс, хайрга;
- ✓ Хаягдал халдваргүйжүүлэх төхөөрөмжөөс гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал, далан, усан сангийн лав /үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаас гарах лаваас бусад/;
- ✓ Ахуйн болон үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний дахин ашиглах боломжгүй, аюулгүй хог хаягдал;
- ✓ Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал багтана.

Энгийн хог хаягдлыг түр хадгалах цэг нь ангилан ялгах боломжтой, бороо ус орохооргүй, хөрсөнд нэвчихгүй байх шаардлагатай байдаг.

Энгийн хатуу хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээгээр зайлуулах гэрээг байгуулна.

Аюултай хог хаягдал

Оффис, үйлчилгээний газрын үйл ажиллагаанаас төслийн үйл ажиллагаанаас оффисын зориулалтаар ашиглах зарим техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хаягдал буюу

ахуйн зориулалтын батерей, принтер, хувилах машины хор зэрэг нь аюултай хог хаягдал болох юм. Иймд эдгээр хог хаягдлыг ахуйн хог хаягдалтай холилгүйгээр тусад хадгалж, эдгээр хаягдлыг хүлээн авах цэгүүдэд нийлүүлэх нь зүйтэй.

Монгол улсад химийн хортой болон аюултай хуванцар хог хаягдлын савыг дахин боловсруулж ашиглах анхны үйлдвэрийг “Цэцүүх трейд” ХХК ашиглалтад оруулсан, ашигласан принтер, хувилах машины хорыг “Электро ВорлдТрейд” ХХК цуглуулан авч, дахин боловсруулж эхлээд байна. Батерей, принтерийн хоронд агуулагдах хүнд металл нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд маш хортой, аюултай хог хаягдлын тоонд ордог. Бидний дунд ашигласан батерейг хазаж, дахин ашиглаж болдог гэсэн ойлголт түгээмэл бий.

Гэхдээ энэ нь хүний эрүүл мэндэд асар их хөнөөлтэй гэдгийг зарим хүмүүс мэддэггүй билээ. Батерей нь асар их хүчтэй хүчил агуулдаг тул ам, хамраа түлэх, улмаар насан туршдаа амт мэдрэхгүй, ярих чадвараа алдаж болох эрсдэлтэй. Мөн төрөл бүрийн хавдар, ургийн гажиг үүсгэх аюултай.

Хог хаягдлын төрлүүд ба хэмжээ: Төслийн хүрээнд дараах хог хаягдалд энгийн болон аюултай хог хаягдлын төрлүүд гарахаар байна. Хог хаягдлын гарцын хэмжээг төсөл хэрэгжүүлэгч хог хаягдлын нэр төрөл бүрээр нь холбогдох эх үүсвэр дээр нь ажлын зураг авалт хийж норматив тогтоох шаардлага тавигдаж байгаа. Бид БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ажиллах хүч, ажлын хоног, хэрэглээний норм, техникийн ээлж гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ

Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал		
Дахин ашиглах боломжтой	Цаас	Оффисын 1 ажилтан сард 0.2кг/хүн бичиг цаасны хаягдал
	Шил	Хүнсний баглаа боодлоос 1 хүн/хон*0.6кг
	Хуванцар,	Хүнсний болон ахуйн хэрэглээнээс 1хүн/хон*0.5
	Резин	Техникийн ээлжийн тоогоор тооцно.
	металл, төмөр	Нийт үүсэх хэмжээнээс: <ul style="list-style-type: none"> • Ундааны сав баглаанаас 1 хүн/хон* 0.3кг • Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарах металлыг тооцоолох боломжгүй байна
Хүнсний хог хаягдал	(гал тогооны хаягдал)	1 хүн хоногт 0.1кг
Бусад хаягдал	Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	1 хүн хоногт 0.15кг
	Ахуйн хэрэглээнээс гарсан дахин ашиглахгүй шингэн хаягдал	Төслийн хүрээнд унд ахуйд ашиглах усны 90 хувь нь ахуйн бохир болж хаягдана.
Барилгын хог хаягдал	Буулгасан барилгын дахин ашиглагдахгүй хаягдал	Тооцоолох боломжгүй
Аюултай хог хаягдал		
Батерей аккумулятор	Хар тугалгатай батерей	Батерей солих ээлжийн тоогоор гарна.
Хаягдал тос ба шингэн түлш	Түлшний тос, дизель	Техникийн ээлжийн тоогоор гарна. Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.

Шингэн хадгалах танк, зөөврийн танк, торхны цэвэрлэгээний хаягдал	Тос агуулсан хаягдал	Тос агуулсан хаягдал нь: <ul style="list-style-type: none"> • Тос агуулсан арчих материалын хаягдал • Тос агуулсан хөрсний хуулдас Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.
	Хаягдал шингэн катализатор	Тооцох боломжгүй. Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглэнэ.
Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал	Хүнд машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

Хог хаягдлыг зайлуулах, устгах. “Хог хаягдлын тухай” хуулийн дагуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах, устгах харилцааг зохицуулах зөвлөмжийг төслийн хүрээнд үүсэх хог хаягдлын нэр төрөл бүрээр авч үзэх шаардлагатай болно. Харин үүссэн хог хаягдлын хэмжээ нэр төрлүүдээр бага, холбогдох эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхөд тээврийн ачааллын хангалттай хэмжээнд хүрэхгүй байж болзошгүй тул төслийн хүрээнд үүсэх хог хаягдлыг нэгдсэн менежментэд шилжүүлж болно гэж үзэж байна.

Хог хаягдлыг зайлуулах арга хэлбэр

Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал	
цаас	Дахин боловсруулах боломжтой тул эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхийн тулд гэрээ хийнэ. Түр хадгалалтын цэгийг хуримтлагдах хэмжээ, тээвэрлэлтийн хугацаатайгаа уялдуулан төлөвлөсөн байна.
шил	
хуванцар,	
резин,	
металл, төмөр	
Хүнсний хаягдал, (гал тогооны хаягдал)	Маш бага хэмжээтэй гарах бөгөөд хэт бохирдолтой, удаан хугацаагаар хадгалах боломжгүй хаягдал тул хамгийн цөөндөө 7 хоногт 2 удаа зайлуулна. Тиймээс эрх бүхий этгээдээр тогтоосон хугацаанд тээвэрлүүлэн зөвшөөрөгдсөн цэгт хүргүүлнэ.
Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	
Шингэн хаягдал	Зөвшөөрөгдсөн цэгт түр хадгалан зөвшөөрөгдөн цэгт зайлуулна.
Аюултай хог хаягдал	
Хар тугалгатай батарей	Аюултай хог хаягдлын зөвлөмжийг баримтална. Эрх бүхий этгээдэд нийлүүлнэ.
Ашигласан тос, масло	Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.
Хаягдал шингэн катализатор	Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглүүлнэ.
Хүнд машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зардал. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг хог хаягдлын нэр төрөл бүрийн менежментийг яаж зохион байгуулснаас хамаарна.

Хог хаягдлын цуглуулах зөвлөмж

ЗӨӨЛӨН ХУВАНЦАРЫН УУТ ХУВАНЦАР УУТ, БАГЛАА БООДОЛ



Энэ уутанд бүх хуванцар уут, зөөлөн хуванцар баглаа боодлоо хийгээрэй. Дэлгүүрийн торнууд, талх, боов, гоймонгийн гялгар уутнууд, бусад хүнсний гялгар уутнууд, мөн хүнсний скоч багтана. Харин бүгд цэвэрхэн байх ёстойг битгий мартаарай! Хэрэв гялгар уут, баглаа хэтэрхий бохирдсон байвал эцсийн хогийн савандаа хийгээрэй.

ХАТУУ ХУВАНЦАРЫН УУТ, ХУВАНЦАР САВНУУД

Энэ уутанд хатуу хуванцар савнууд болон бусад хатуу хуванцар хаягдлуудаа хийгээрэй. Жишээ нь ус ундаа, пивоны сав, кетчуп, шампунь, аяга таваг угаагчны сав, тараг бусад хүнсний сав, мөн канистра болон бусад эвдэрсэн хатуу хуванцар эдлэл орно. Хуванцар савыг өнгө, төрлөөр нь ялгах ёстойг анхаарна уу.



ЦААС, БӨС ДААВУУНЫ УУТ, ЦААС, КАРТОН, СҮҮ ЖҮҮСНИЙ САВ, БӨС ДААВУУ

Энэ уутанд та дахин хэрэглэж эсвэл галд шатаадаггүй бол бүх төрлийн картон, цаасаа хийгээрэй. Нэг дор дахин боловсруулахгүй боловч тетрапак сав буюу сүү, жүүсний савнуудаа мөн бөс даавууны хаягдлуудаа энд хийгээрэй. Дараа нь салгаж ангилахад бидэнд хялбар байх болно.



ШИЛНИЙ УУТ, ШИЛЭН ЛОНХ, ШИЛЭН САВНУУД

Энэ уутанд та бүх төрлийн шилнүүдээ хийгээрэй. Архины шил болон бусад лонхнууд, хүнсний шилэн савнууд (огурцы, компот, жимсний чанамал, салатны шил гэх мэт). Шуудайд хийхдээ шилнууд хоосон, цэвэрхэн байх ёстойг битгий мартаарай. Сайтар угаах шаардлагагүй ч хөнгөхөн зайлах хэрэгтэй шүү.



ХҮНСНИЙ ХАЯГДЛЫН САВ, НОГОО БОЛОН МАЛЫН ГАРАЛТАЙ ХАЯГДАЛ



Жимс
ногооны
хаягдлын сав

Малд өгөх эсвэл
бордоо хийх



Өрхийн
хүнсний
хаягдал



Амьтны
гаралтай
хаягдлын сав

Нохойд өгөх эсвэл
цэгт хүргэх

Хүнсний хог хаягдал бусад дахиваруудыг бохирдуулж, дахин боловсруулах боломжгүй болгодог тул тусад нь ангилах маш чухал. Болж өгвөл 2 тусдаа саванд хийгээрэй:

Ногооны хальс болон бусад ногоон хаягдлыг малд өгөх эсвэл хашаандаа бордоо болгон ашиглаж болно.

Амьтны гаралтай хаягдал үнэр орж, амьтан, шавьж татах эрсдэлтэй тул ногооны хаягдалтай холихгүй байхыг зөвлөө. Хэрэв нохойд өгөх боломжгүй бол нэгдсэн хогийн цэгт авчирч өгөөрэй. Харин бусад хогтой огт холихгүй, цэвэрхэн байлгах ёстойг санаарай.

ЭЛЕКТРОН ХАЯГДЛЫН УУТ, Э-ХАЯГДАЛ БОЛОН ЗАЙ

Энэ уутанд та эвдэрсэн бүх төрлийн электрон бараагаа хийгээрэй. Бүгдийг нь дахин боловсруулах боломжгүй ч зарим хэсгийг дахин боловсруулж эсвэл сэлбэгэнд дахин ашиглах боломжтой байдаг. Бүх төрлийн баттерэй нь байгаль орчныг бохирдуулагч маш хүнд хортой найрлагуудыг агуулдаг, тиймээс тэднийг хогийн цэгт очиж хөрс, ус, агаар бохирдуулахаас нь сэргийлэн зөв ангилж, зохистой газар нь хүргэх шаардлагатай юм.



МЕТАЛ ХАЯГДЛЫН УУТ, ЛААЗ БОЛОН БУСАД МЕТАЛУУД

Энэ шуудайнд та бүх төрлийн метал хаягдлаа хийгээрэй. Гэрээс тань хөнгөн цагаан лааз болон хүнсний төмөр лаазнууд дийлэнхдээ гарах болов уу. Бас өөр эвдэрсэн бүх төрлийн метал зүйлсээ хийж болно. Металыг зогсолтгүй дахин боловсруулах боломжтой байдаг.



ЭЦСИЙН ХОГИЙН САВ, ДАХИН БОЛОВСРУУЛАГДАХГҮЙ БУСАД БҮХ ТӨРЛИЙН ХОГ
Та бүх хогоо ангиллуудын дагуу зөв ангилж чадвал эцсийн хог маш бага хэмжээгээр гарах ёстой. Харин та огт хоггүй амьдрах гэж хичээсэн ч ямар нэг байдлаар эцсийн хог заавал гарах болно. Тиймээс эцсийн хогоо хийх сав зайлшгүй хэрэгтэй. Энэ савыг аль болох жижигхэн байлгахаар хичээж болно шүү дээ!

ХОГ АНГИЛАХ САВНЫ 4 ДҮРЭМ

1. ГЭР ДОТРОО ТҮР ЦУГЛУУЛАХ САВ ГАРГАЖ АШИГЛАХ

Энэ нь дүрэм гэхээсээ илүү зөвлөгөө юм: Гэрээс гарах бүх дахивар хаягдлаа том картон хайрцаганд хадгалж байгаад дүүрэхээр нь ангилах савандаа ялгаж хийгээрэй. Ингэснээр хогоо өдөр тутам ангилахад илүү хялбар болно.

2. ӨӨРСДИЙН ХЭРЭГЛЭЭНДЭЭ ТОХИРУУЛЖ САВАА АШИГЛАХ

Хог ангилах тохиромжтой сав нь хэрэглэгчдээ яг таарсан байх ёстой. Иймээс бид энэ савыг өөртөө тохируулж болохоор хийсэн. Та гарах хогныхоо хэмжээ, бүтцээс хамаараад тус саванд хэдэн ч уутыг хэрэгцээндээ тохируулан яаж ч байрлуулах боломжтой. Хамгийн гол нь хогоо заасан ангилалуудын дагуу ангилах юм.

3. ДАХИН БОЛОВСРУУЛАГДАХ ХАЯГДЛАА ЦЭВЭРХЭН АНГИЛАХ!

Энэ дүрэм нь голдуу хоол хүнс, ундааны саванд хамаарах ч маш чухал юм. Ангилдаг дахиваруудаа цэвэрхэн байлгаарай. Савангаар угаах хэрэггүй ч ангилах савандаа хийхээсээ өмнө багахаан усаар зайлаад хийгээрэй. Эс бөгөөс бусад дахиварууд бохирдож дахин боловсруулах боломжгүй болно.

4. АНГИЛАХ САВАН ДАХЬ ХОГОО СУМААС ТУСГАЙЛАН ЗААСАН ТАЛБАЙД ХҮРГЭЖ АСГАХ

Ангилах саван дахь шуудайнуудаа дүүрэхээр та ангилсан хогоо Экосум ТББ болон орон нутгийн захиргаанаас зааж өгсөн газарт хүргэж өгөөрэй.

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зардал

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал,төг	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа,	Баримтлах эрх зүйн баримт бичиг
– Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлыг ялган ангилах	Хог хаягдал үүсэх бүрт, бүх ажилтан	ш	200 000	4 ш	1 100 000	Хог хаягдал үүсэх бүрт	Хог хаягдлын тухай хууль 2017 он MNS 5344:2003
– Хог хаягдлын төрөл, хэмжээ болон түүнийг цуглуулах, зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцсан ажилтнуудад шаардлага тавих	Байгаль орчны мэргэжилтэн Тогтмол	ш	200 000	1 ш		Тогтмол	
– Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлд анхаарч ажиллах	Хогийн түр цэг бүрт	-	300 000	-		2023 онд	
– Орон нутгийн тохижуулах газартай гэрээ байгуулж, гэрээний дагуу хогийг төвлөрсөн цэгт тээвэрлэх	“Сунно Интернэшнл” ХХК Төслийн турш	кг	400 000	Хоногт 32.4 кг Сард 972 кг Жилд 8100 кг		Төслийн хэрэгжүүлэх явцад	

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас орчны агаар, ус, хөрсөнд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ОХШХ-т төсөл хэрэгжих газрын агаарын чанар, усны чанар, хөрсөн бүрхэвч, дуу чимээний нөлөөлөл зэрэг хяналт шинжилгээний үзүүлэлт, хэмжилт хийх, дээж авах байршил, хугацаа, давтамж, холбогдох стандарт болон эдгээр ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зардлын төсвийг тооцоолов.

ОХШХ-ыг байгаль орчны мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлж, хяналт тавьж, тухайн бүрт нь тайлагнан ажиллана.

2022 оны БОМТ-нд Аялал жуулчлалын бааз төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт **900,420 мян.төг** зарцуулахаар тусгагдсан. Үүний дагуу ОХШХ-ийг боловсруулахдаа лабораторийн шинжилгээний дараах тарифийг үндэслэл болгов.

Лабораторийн шинжилгээний тариф

№	Шинжилгээний төрөл	Үнэ, ₮	Шинжилгээ хийлгэх хугацаа	Итгэмжлэгдсэн лаборатори
1	Агаарын чанарын шинжилгээ (SO ₂ , NO ₂ , CO)	23.000	4-р сар	УЦЦОШГ-ын БОХЗТЛ
	Тоосны үзүүлэлт (PM10, PM2.5, TSP)	15.000		
	Техникчийн томилот	20.000		
2	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	25.000	9-р сар	“Инженер геодези” ХХК
	Хөрсний бохирдлын шинжилгээ (1 дээжинд 6 элемент: Cu, Cr, Cd, Pb, Zn, Ni)	25.000		
	Хөрсний бактериологийн шинжилгээ	22.000		
3	Ундны усны бүрэн шинжилгээ	43.000	9-р сар	“Монгол ус” ТӨААТҮГ
	Усны бохирдлын шинжилгээ (1 дээжинд 22 элемент)	78.000		
	Усны бактериологийн үзүүлэлт	45.210		

2023 оны ОХШХөтөлбөр

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян, төг	Нийт зардал мян, төг	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаар орчин	Агаарын чанарын шинжилгээ Нийт тоос Хүхрийн исэл SO ₂ , Азотын исэл NO ₂ Дуу шуугиан	Зам барилгын ажлын талбайд - Салхин доод талд 20-40 м-ийн бүсэд жилд 2 удаа Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторийн техникчийн хамт гүйцэтгэнэ.	Зөвхөн нийт тоос болон SO ₂ , NO ₂ шинжилнэ. 2 дээж * 43 000 = 86 000 Техникчийн томилолт 20 000 төгрөг 1 удаагийн хэмжилт, дээжлэлтийн зардал 106 000 * 2 = 212 0	212.0	MNS (ISO) 4225:2001 MNS 4585:2007 MNS 3384:1982 MNS 5365:2004 MNS 17.2.316-1988 MNS 3383:1982 MNS5885:2008 MNS (ISO) 5667-4:2001 MNS-4048:88 MNS 6063:2010.
Хөрсөн бүрхэвч	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	Аялал жуулчлалын талбайд Нийт 2 цэг /Жилд 2 удаа, 04, 09 сар/	Нэг удаагийн дээжлэлт: 2цэг* 25 000 = 50 000	172.0*2=344.0	MNS 3298:1991 “Хөрснөөс шинжилгээнд дээж авахад тавигдах шаардлага” MNS 3297-91 “Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлэлт, үзүүлэлтийн төрөл” MNS 5850:2019 хөрс бохирдуулагч бодис,элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хөрсний бохирдлын шинжилгээ Cd /кадми/, Pb /хартугалга/, Cr /хром, Zn /цайр/, Cu /зэс/, Ni /никель/	Хог хаягдлын 1 цэгт, Амрагчдын гэрийн ойролцоо 1 цэгт, Уурын зуухны ойролцоо 1 цэгт, Бохирдол үүсгэж болзошгүй дурын 1 цэг Нийт 4 цэг /Жилд 2 удаа, 04, 09 сар/	4 цэг* 25 000 = 100 000		
	Хөрсний бактерлогийн шинжилгээ	Барилгын ажилчдын талбайн хог хаягдлаар бохирдож болзошгүй цэг сонгох /Жилд 2 удаа, 04, 09 сар/	1 цэг * 22 000 = 22 000		

Усан орчин	Төслийн талбайд хамгийн ойр байрлах газрын доорх усны чанарын хяналтыг хийх	Ажилчдын хэрэглэж буй унд ахуйн уснаас Нийт 1 дээж /Жилд 2 удаа, 04, 09 сар/	Ерөнхий хими 43 000 * 1 дээжийн тоо = 43 000	172.210*2 = 344.420	MNS 4586:1998
	Бохир усны чанар		Бохир усны химийн 42000 * 1 = 42 000		MNS 4079:1988
	Усны бохирдлын шинжилгээ		1 * 42000 = 42 000		MNS (ISO) 5667-1:2002
	Бактериологийн үзүүлэлт		Ундны ус		Нийт 5 төрлийн үзүүлэлтээр 1 * 45 210 = 45 210
Дуу чимээ	Барилгын талбайн хамгийн их дуу чимээ гарч буй хэсэгт дуу чимээний түвшиний хэмжилт судалгаа хийх	Жилд 2 удаа, 3 цэгт	Өөрийн багаж	-	MNS (ISO) 4867:1999
					MNS (ISO) 5667-10:2001
					MNS (ISO) 5667-11:2000
					MNS (ISO) 11083:2001
					MNS 4047:1988
					MNS 2570:1978
					MNS 3936:1986
Нийт төсөв				900 420	

АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Аливаа байгууллагын байгаль орчны асуудлыг хариуцах, удирдан зохион байгуулах бүтэц нь ISO 14001 2004 (MNS 2006) стандартад заасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) бөгөөд үүнд тухайн байгууллагын байгаль орчны бодлогын хүрээнд төлөвлөх-хэрэгжүүлэх-хянах-шийдэх гэсэн 4 үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж байгаль орчны үзүүлэлт байнга сайжирч байх нөхцлийг бүрдүүлдэг. Менежментийн тогтолцоонд байгууллагын бүтэц, төлөвлөлт, хариуцлага, практик үйл ажиллагаа, бодлого, дүрэм журмын баримт бичиг, процесс, нөөцийг хамааруулдаг (ISO 14001, 2004).

БОУТ-ны бүрдэл хэсэг, үйл ажиллагааны товч тайлбар:

Байгаль орчны бодлого: Тухайн байгууллагын байгаль орчны үзүүлэлтийн талаар дээд удирдлагаас тогтоосон зорилт, чиглэл юм.

Төлөвлөлт: Байгаль орчны асуудал, хууль журам, стандартын шаардлага, байгаль орчны талаар баримтжуулж, баталгаажуулсан зорилго, зорилт, хөтөлбөр;

Хэрэгжүүлэлт: Хүн, материал, технологи, дэд бүтэц, санхүүгийн нөөц, үүрэг, хариуцлага, захиргаа, ажиллагсдын мэдлэг чадвар, сургалт, харилцаа холбоо, байгаль орчны баримт бичиг болон үйл ажиллагааны хяналт, удирдлага, онцгой нөхцлийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах ажиллагаа;

Хяналт, сайжруулалт: Хяналт шинжилгээ, хэмжилт, гүйцэтгэлийн шалгалт, дутагдал, доголдлыг засах, сайжруулах, сэргийлэх, бүртгэлийн хяналт удирдлага, дотоод аудит;

Удирдлагын хяналт: Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг хянаана.

“Сунно Интернэшнл” ХХК-ний Аялал жуулчлалын бааз төслийн барилгын ажил үргэлжлэх явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийг оролцогч талуудад нээлттэй байх гэсэн зарчмын дагуу төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн удирдлага болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал авах зорилгоор тус арга хэмжээнд төсөвлөсөн.

Удирдлага зохион байгуулалт, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ

№	Төлөвлөсөн арга	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
1	Байгууллагын удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг тайлагнах (ISO 14001, 2004).			Компаний удирдлага, орон нутгийн иргэд, БО-ны мэргэжилтэн, орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллага
2	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	Дотоод зардал	Төслийн үйл ажиллагааны турш	
3	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дүрсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Нэмэлт зардалд тусгах	Тухай бүрт нь	“Сунно Интернэшнл” ХХК
4	Компанийн зүгээс гэрээт байгууллагуудад тавих байгаль орчны хяналтыг баталгаажуулж, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хамгаалах, гал түймэр, ослын үед дагаж мөрдөх журмын талаар гэрээнд нарийвчлан тусгах	1 000 000	Төслийн үйл ажиллагааны турш	Компаний удирдлага, гэрээт байгууллагууд

АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлууд	Хугацаа
1	Налайх дүүргийн 6-р хорооны нутаг, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт БОМТ-ны хэрэгжилтийн тайланг хүлээлгэн өгөх, хянуулах /цахим хэлбэрээр/	2023 оны 11-р сарын 01-ны дотор
2	БОМТ-ны хэрэгжилтийн тайланг “Нийслэлийн байгаль орчны газар”-т хүргүүлж, тайлагнана. /цахим хэлбэрээр/	2023 оны 11 сард
3	БОМТ-ны хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-д хүргүүлэх, батлуулан төлөвлөгөөний дагуу ажлын биелэлтэд хяналт тавин ажиллана. /цахим хэлбэрээр/	2023 оны 12 сард

Сунно Интернэшнл ХХК-ний “Аялал жуулчлалын бааз” төслийн БОМТ 2023 оны төсөв

Менежментийн төлөвлөгөө	БОМТ арга хэмжээний зардлын товчоо	
	Зардлын хэмжээ	Тайлбар
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	-	
Орчны тохижилт нөхөн сэргээлт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	2 935 800	
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	450 000	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1 100 000	
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	900 420	
Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	1 000 000	
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-	
Нийт дүн	6 386 220	

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тушаал “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
- Төслийн талбайд хийсэн хээрийн судалгааны материал /2022-10-р сар /
- Шинжилгээний дүнгүүд

ХАВСРАЛТУУД

- A. Шинжилгээний дүнгүүд - 2022 он
- B. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар
- C. ТХГН-т газар ашиглах гэрчилгээний хуулбар
- D. Хог хаягдлын гэрээний хуулбар
- E. Худгийн паспортны хуулбар
- F. Батлагдсан БОННУ-ний нүүрний хуулбар
- G. Хяналтын хуудас